



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын нэр: “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудит

ҮАГ-НАГ/2018/01-НА-ХөТАГ

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн нийцлийн аудитын тайлан

Аж, ахуйн нэгжүүд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгүүлээгүй, хуульд заасан мэдээллийг улирал бүр мэдээлэхгүй зөрчил давтагдаж байна.

**Хөвсгөл аймаг
2018 оны 11 дүгээр сар**



АГУУЛГА

<p>Тайланг бэлтгэсэн: ХөТАГ-ын Нийцлийн аудитын алба</p> <p>Тэргүүлэх аудитор О.Ганболд Утас: 99382500</p> <p>Аудитын менежер Ж.Отгончимэг Утас: 99382811</p> <p>Багийн гишүүн: Ахлах аудитор Л.Энх-Амгалан Б.Тэгшдэлгэр Аудитор Э.Бат-Эрдэнэ С.Гансүх Б.Давааням Л.Мандахнаран</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70384043. 70384044 дугаарын утсаар харилцана уу.</p> <p>Тайланг УАГ-ын веб сайт-аас үзнэ үү. www.audit.mn</p> <p>ХАЯГ: Мөрөн сум Аймгийн ЗДТГ-ын “А” корпус 3 давхар</p>	<p>Товчилсон үгийн жагсаалт</p> <p>Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй</p> <p>Үндсэн мэдээлэл</p> <p>Бүлэг 1. Байгууллагууд шилэн дансны мэдээллийг иж бүрэн байршуулдаггүй зөрчлийг гаргасаар байна.</p> <p>1.1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд хуулийн 6.1-д заасан мэдээллийг 94.7 хувьтай мэдээлсэн байна.</p> <p>1.2. Улсын болон орон нутгийн төсвийн байгууллагууд түүний захирагчид шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт хуульд заасан хугацаанд байршуулж байна.</p> <p>Бүлэг 2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 хамаарах нийт 169 аж ахуйн нэгж аудитад хамрагдсанаас 26,242.3 сая төгрөгийн санхүүжилтийг мэдээлээгүй байна.</p> <p>2.1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллагууд шилэн дансны мэдээллийг 76.8 хувийн гүйцэтгэлтэй мэдээлсэн байна.</p> <p>2.2 Хуулийн 3.1.4-д хамаарах аж ахуйн нэгжүүд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, ТАХ-ний талаарх 26,242.3 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансанд мэдээлээгүй байна.</p> <p>2.3 Хуулийн 3.1.5-д хамаарах байгууллагууд шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.</p> <p>Бүлэг 3. Санхүүгийн хяналт, аудитын алба нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийхдээ мэдээллийн агуулга, стандарт, үнэн зөв эсэхийг үнэлээгүй байна.</p> <p>3.1. Шилэн дансны тухай хуульд заасан хяналт тавих эрх бүхий байгууллагууд мэдээллийн чанарт анхаараагүй байна.</p> <p>3.2. Байгууллага албан тушаалтын ажлын тайланг дүгнэхдээ шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг харгалзан үзэхгүй байна.</p> <p>3.3. Иргэн, хуулийн этгээдээс хуулийн хэрэгжилттэй холбоотой санал, гомдол ирүүлээгүй байна.</p> <p>3.4 Өмнөх аудитаар өгсөн 7 зөвлөмжөөс 3 зөвлөмж хэрэгжээгүй байна.</p> <p>Дүгнэлт</p> <p>Зөвлөмж</p> <p>Холбогдох байгууллагын санал</p> <p>Саналд өгсөн тайлбар</p> <p>Хавсралт</p>	<p>3</p> <p>4</p> <p>5</p> <p>6</p> <p>10</p> <p>11</p> <p>13</p> <p>14</p> <p>30</p> <p>31</p>
---	---	---

Товчилсон үгийн тайлбар

Товчилсон үг	Тайлбар
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ХөТАГ	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ХК	Хувьцаат компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1.1 Аудит хийх үндэслэл

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

1.2 Аудитын зорилт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд аудит хийж, дүнг холбогдох байгууллага албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтуудыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ.

- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1¹, 3.1.2²-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3³, 3.1.4⁴, 3.1.5⁵-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх
- Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх.

1.3 Аудитын хамрах хүрээ

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтнуудыг хамруулан 2017 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хугацаанд мэдээллээ байршуулсан эсэхэд аудит хийлээ.

1.4 Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, анхан шатны баримт материалыг данс бүртгэлтэй тулгах харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, зэрэг арга зүйг ашиглав.

1.5 Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитад дараах хууль, эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгов.

- МУ-ын 2017 оны төсвийн тухай хууль;

¹ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

² Төрийн өмчит үйлдвэрийн газрууд

³ Хяналтын баац буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компаниуд

⁴ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд

⁵ Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид

- Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Төрийн болон албаны нууцын тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”
- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- Аймгийн ИТХ-ын төсөв баталсан тогтоолууд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Ганболд хянан удирдаж, аудитын менежер Ж.Отгончимэг явцын болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Л.Энх-Амгалан арга зүйгээр ханган, ахлах аудитор Б.Тэгшдэлгэр, аудитор Э.Бат-Эрдэнэ, С.Гансүх, Б.Давааням, Л.Мандахнаран нар 2018 оны 11 дүгээр сарын 05-аас 11 дүгээр сарын 27-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл

Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий Шилэн дансны тухай хууль 2015 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.

Шилэн дансны тухай хуулийн⁶ зарчим нь мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн, ойлгомжтой, ач холбогдолтой, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх явдалд үндэслэгдсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 7 төрлийн мэдээлэл, 3.1.2-т заасан төрийн өмчит үйлдвэрийн газар 7 төрлийн мэдээлэл, 3.1.3-т заасан хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани 3 төрлийн мэдээлэл тус бүр оруулахаар хуульчилсан байна.

⁶ Цаашид хуулийн гэх

Хөвсгөл аймгийн тухайд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2015, 2016 онуудад жилд тус бүр 2 удаа аудит хийж, 2017 онд 1 удаа аудит хийж хуулийн хэрэгжилтийг тайлагнасан байна.

2017 онд гүйцэтгэсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитаар хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан байгууллагуудын 52.2% нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгүүлээгүй, 20.3% нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгүүлсэн боловч хуульд заагдсан мэдээллийг тогтоосон хугацаанд нийтэд ил тод мэдээлээгүй 2,458.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж, аудитын явцад залруулж ажилласан байна.

2018 оны 11 дүгээр сард хийж гүйцэтгэсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитаар улсын төсвийн 38, төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагч 25, орон нутгийн төсвийн 174 байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 16, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани 15, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж 169, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 7 байгууллага нийт 444 байгууллагыг хамрууллаа.

БҮЛЭГ 1: БАЙГУУЛЛАГУУД ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЛИЙГ ИЖ БҮРЭН БАЙРШУУЛДАГГҮЙ ЗӨРЧЛИЙГ ГАРГАСААР БАЙНА.

1.1 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд хуулийн 6.1-д заасан мэдээллийг 94.7 хувьтай мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1⁷ болон 3.1.2⁸ -д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хамрагдсан байдлыг хүснэгтээр харуулав.

Хүснэгт1:

№	Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-д хамаарах байгууллагууд	Шилэн дансанд бүртгэлтэй байгууллагын тоо	Хамрагдсан тоо
1	Улсын төсвийн байгууллага	38	38
2	Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагч	25	25
3	Орон нутгийн төсвийн байгууллага	174	174
	Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	16	16
	Нийт дүн	253	253

Дээрх байдлаас харахад: Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдсан байна.


Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 01 дүгээр сарын 15-ны 02 дугаар тогтоолоор суманд эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаа явуулж

⁷ 3.1.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

⁸ 3.1.2 Төрийн өмчит үйлдвэрийн газар

байсан 24 Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийг татан буулгаж, “Хөвсгөл Эмийн эргэлтийн сан” ХК-ийг шинээр үүсгэн байгуулсан байна.

Хуулийн 3.1.1 болон 3.1.2-т заасан байгууллагууд нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.1–д заасан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд



тогтоосон хугацаанд ил тод мэдээлсэн эсэхийг графикаар харуулбал.

Графикаас харахад:

- ❖ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-6.1.6-д заасан тогтмол мэдээллүүдийг **83%-97.6%**-тай мэдээлсэн байна.

Аудитад хамрагдсан нийт 253 байгууллага Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан тогтмол мэдээлэх нийт 5532 мэдээллээс 4998 мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлж, **244** мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, **290** мэдээллийг мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг Хөвсгөл аймгийн хэмжээнд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд **94.7%**-иар мэдээлсэн байна.

Хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд хуулийн 6 дугаар зүйлийн 6.4⁹ дэх хэсэгт заасан мэдээллийг дараах байдлаар мэдээлсэн байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2:

№	Хуулийн заалт	Мэдээлбэл зохих мэдээллийн нэр	Мэдээлбэл зохих тоо	Мэдээлсэн байдал	
				Тоо	Хувиар
1	6.4.1	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	253	251	99%
2	6.4.2	Тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	137	134	98%
3	6.4.3	Тендер, худалдан авалттай холбоотой мэдээлэл	253	235	93%

⁹ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.

4	6.4.4	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл	1271	1248	98.2%
5	6.4.5	Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	2394	2378	99.3%
6	6.4.5	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	4781	4644	97.1%
7	6.4.6	Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	252	244	97%
8	6.4.7	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	238	237	99.6%
9	6.4.8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	1949	1890	96.9%
Нийт дүн			11528	11261	97.7%

Хүснэгтээс харахад: Шилэн дансны тухай хуулийн 6.4.1-6.4.8-д заасан долоо хоногийн дотор оруулах мэдээллийг хуулийн 3.1.1 болон 3.1.2-т заасан байгууллагууд 93%-99.6% -иар мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт заасан долоо хоногийн дотор мэдээлэх нийт 11528 мэдээллээс 11261 мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлж, 267 мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд **97.7%**-иар мэдээлсэн байна.

- ❖ Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээтэй холбоотой 23,504.2 сая төгрөгийн мэдээллээс 348.4 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байна.
- ❖ Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний тухайд: Орлогын 206,897.1 сая төгрөгийн гүйлгээнээс 5,237.6 сая төгрөгийн гүйлгээг, зарлагын 141,815.1 сая төгрөгийн гүйлгээнээс 207.5 сая төгрөгийн гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.
- ❖ Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 -д заасан бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн нийт 12,525.2 сая төгрөгийн мөнгөн дүн бүхий мэдээллээс 317.2 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.

Төсөв, өмч, хөрөнгө зарцуулах болон өр, авлага, орлого, зарлагатай холбоотой дараах мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байна. **Тухайлбал:**

- ❖ Тариалан сумын Соёлын төв 82.3 сая төгрөгийн халаалт, гэрэл цахилгааны зардалтай холбоотой үүссэн өрийг мэдээлээгүй.

- ❖ Тосонцэнгэл сумын ЗДТГ төсөв, өмч, хөрөнгө зарцуулахтай холбоотой 5.0 сая төгрөгийн 4 шийдвэрийг мэдээлээгүй.
- ❖ Улаан-Уул сумын ЕБС-ийн дунд сургууль төсөв, өмч зарцуулахтай холбоотой 147.9 сая төгрөгийн 21 шийдвэрийг мэдээлээгүй байна.
- ❖ Рашаант сумын Хүүхдийн цэцэрлэг төсөв, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой 18.2 сая төгрөгийн 5 шийдвэрийг мэдээлээгүй байна.
- ❖ Цагаан-Уул сумын ЭМТ орлоготой холбоотой 383.3 сая төгрөгийн 12 гүйлгээг мэдээлээгүй
- ❖ Жаргалант сумын ЗДТГ 227.2 сая төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй
- ❖ Жаргалант сумын ЭМТ орлоготой холбоотой 130.9 сая төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй
- ❖ Рашаант сумын ЕБС зарлагатай холбоотой 93.5 сая төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй байна.
- ❖ Бүрэнтогтох сумын ЭМТ зарлагатай 58.0 сая төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй байна./Дэлгэрэнгүйг хавсралт-2 оос харна уу/

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 “Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах”, 9 “Албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдалд мэдэгдэх” дүгээр зүйлүүдэд заасан мэдэгдлийг Нийгмийн даатгалын хэлтэс, “Хөвсгөл ус суваг” ХХК, “Тариалан НААҮТ” ХХК, “Их-Уул дулаан” ХХК, “Тосон-Илч” ХХК тус тус мэдээлээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт заасан мэдээлбэл зохих нийт **384,749.6** сая төгрөгийн мэдээллээс **267** мэдээллийн **6,110.7** сая төгрөг буюу **1.6** хувийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт:3

№	Хуулийн заалт	Мэдээлээгүй мэдээллийн тоо	Мэдээлээгүй мэдээллийн мөнгөн дүн /сая.төг/
1	6.4.4 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт	23	348.4
2	6.4.5 5 сая төгрөгөөс дээш зарлагын мэдээлэл	16	207.5
3	6.4.5 5 сая төгрөгөөс дээш орлогын мэдээлэл	137	5,237.6
4	6.4.8 Төсөв, өмч хөрөнгө, өр, авлагатай холбоотой шийдвэр	42	317.2
	Нийт дүн	218	6110.7

Хүснэгтээс харахад Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол “ Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.1¹⁰ болон 3.2¹¹-д заасан мэдээллийг тогтоосон хугацаанд иж бүрэн, зөв оруулаагүй байна.

Шилэн дансны мэдээллийг иргэн олон нийтэд хүргэх хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3¹² дэх хэсэгт заасан албан тушаалтны ажлын хариуцлагагүйгээс дээрх зөрчлүүд бий болсон байна.

¹⁰ Төсвийн ерөнхийлөн захирагч дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ.

¹¹ Төсвийн байгууллага дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ.

¹² Тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан

1.2 Улсын болон орон нутгийн төсвийн байгууллагууд түүний захирагчид шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт хуульд заасан хугацаанд байршуулж байна.

Шилэн дансны тухай 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3-д заасан байгууллагууд хуулийн 5 дугаар зүйлийн 5.7¹³-д заасны дагуу шилэн дансны мэдээллийг мэдээллийн самбарт байршуулж хэвшсэн байна.

Бүлэг 2: Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 хамаарах нийт 169 аж ахуйн нэгж аудитад хамрагдсанаас 26,242.3 сая төгрөгийн санхүүжилтийг мэдээлээгүй байна.

2.1 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллагууд шилэн дансны мэдээллийг 76.8 хувийн гүйцэтгэлтэй мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллагууд бүрэн хамрагдсан байна. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан хяналтын багц буюу түүнээс дээш хувийг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа нийт 15 аж ахуйн нэгж шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгэлтэй байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хамаарах компаниуд нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.8¹⁴ -д заасны дагуу мэдээлбэл зохих 173 мэдээллээс 132-ыг нь мэдээлж, нийт мэдээллийн 23.2 хувийг буюу 41 мэдээллийг мэдээлээгүй байна.

Тухайлбал:

- ❖ Орон нутгийн өмчит “Тариалан НААҮТ” ХХК 79.9 сая төгрөгийн өрийн мэдээлэл болон тендер худалдан авалттай холбоотой 13 худалдан авалтын 277.2 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.
- ❖ “Тосон-Илч” ХХК тендер худалдан авалттай холбоотой 10 мэдээллийн 109.5 сая төгрөгийн худалдан авалтыг мэдээлээгүй байна.
- ❖ “Их-Уул Дулаан” ХХК тендер худалдан авалттай холбоотой 8 мэдээллийн 157.0 сая төгрөгийг мэдээлээгүй байна.
- ❖ “Хоймор нутгийн чулуу” ХХК сум хөгжүүлэх сангаас авсан 40.0 сая төгрөгийн өр, түүний шийдвэрийн талаарх мэдээллийг байршуулаагүй байна.
- ❖ Шинэ-Мөрөн худалдааны төв ХК шилэн дансанд бүртгэлтэй боловч шилэн дансны мэдээллийг огт мэдээлээгүй байна. /Дэлгэрэнгүйг 3 дугаар хавсралтаас оруулна уу/.

2.2 Хуулийн 3.1.4-д хамаарах аж ахуйн нэгжүүд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, ТАХ-ний талаарх 26,242.3 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансанд мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т хамаарах байгууллагууд хуулийн 6 дугаар зүйлийн 6.9¹⁵-д заасан мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.

¹³ Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай хэсгээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна.

¹⁴ Энэ хуулийн 3.1.3-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.

¹⁵ Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 –т заасан үйлчлэлд хамаарах аж ахуйн нэгжүүд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 10.0 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, ТАХ-ний талаар мэдээлбэл зохих 247 мэдээллийн 57,770.2 сая төгрөгөөс **141** мэдээллийн **26,242.3** сая төгрөгийг мэдээлээгүй байна.

Дээрх аж, ахуйн нэгжүүд нь төсөл арга хэмжээний төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага санхүүжилтийн талаарх мэдээллийг улирал бүр мэдээлээгүй нь Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 5.1¹⁶-дэх заалтыг зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 4-өөс харна уу/

2.3 Хуулийн 3.1.5-д хамаарах байгууллагууд шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-т заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гүйцэтгэж байгаа байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулж байгаа хэдий ч төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа 7 байгууллагаас **4 байгууллага 224.0** сая төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 5-аас харна уу/.

БҮЛЭГ 3: Санхүүгийн хяналт, аудитын алба нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийхдээ мэдээллийн агуулга, стандарт, үнэн зөв эсэхийг үнэлээгүй байна.

3.1 Шилэн дансны тухай хуульд заасан хяналт тавих эрх бүхий байгууллагууд мэдээллийн чанарт анхаараагүй байна.

Шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын хяналт дараах байдалтай байна. Үүнд:

- ❖ Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1- дэх хэсэгт заасан бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал нь хуулийн 3.1.4 болон 3.1.5-д заагдсан аж ахуйн нэгж байгууллагад хөндлөнгийн хяналт хийгээгүй байна.
- ❖ Санхүүгийн хяналт, аудитын алба нь шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.1 болон 3.2-т заасан агуулгатай нийцүүлээгүй байна. Иймд нийцлийн аудитаар хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан байгууллагын шилэн дансны мэдээлэлтэй холбоотой **6,110.7** сая төгрөгийн зөрчил илэрлээ.

хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй.

¹⁶ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн талаар улирал бүрийн мэдээллийг дараа сарын 15-ны дотор энэ журмын 19 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар мэдээлнэ.

Аудитаар илэрсэн зөрчилд үндэслэн Санхүүгийн хяналт, аудитын албаны даргад хариуцлага тооцуулах тухай албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

3.2 Байгууллага албан тушаалтын ажлын тайланг дүгнэхдээ шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг харгалзан үзэхгүй байна

Аймгийн ТЕЗ түүний харьяа байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэхдээ Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4¹⁷ -д заасны дагуу аудитад хамрагдсан байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт болгож, үр дүнг бодитой үнэлээгүйгээс зөрчил давтагдах шалтгаан болж байна.

Хөрөнгө зарцуулах, тендер худалдан авалттай холбоотой зөрчлүүд нийцлийн аудитаар давтагдсаар байгаа бөгөөд ТЕЗ, ТТЗ-д тендерийн ерөнхий мэдээллийг мэдээлээгүй, хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4–т заасан үйлчлэлд хамаарах аж ахуйн нэгжүүд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний талаар мэдээллээ байршуулаагүй байна.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ шилэн дансны хөтлөлтийг шалгуур үзүүлэлт болгоно гэж тусгасан боловч хэрэгжилт хангалтгүй байна.

3.3 Иргэн, хуулийн этгээдээс хуулийн хэрэгжилттэй холбоотой санал, гомдол ирүүлээгүй байна.

Орон нутгийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд иргэдээс хяналт тавьж буй эсэхийг иргэдийн хандалтаар харах боломжгүй байна.

Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1¹⁸ -д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс Төрийн аудитын байгууллагад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, мэдээлэл ойлгомжгүй, ач холбогдолгүй байгаа талаар санал, гомдол ирүүлээгүй байна.

¹⁷ Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно.

¹⁸ Энэ хуулийн хэрэгжилтийн явц, шилэн дансны мэдээллийн зөрчил, дутагдал болон шаардлагыг байгууллага, албан тушаалтан хүлээн аваагүй бол энэ талаарх гомдол, мэдээллийг иргэн, хуулийн этгээд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу төрийн аудитын байгууллагад гаргах бөгөөд энэ хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын үйл ажиллагаанд аудитын дүгнэлт гаргуулах хүсэлт гаргаж болно.

3.4 Өмнөх аудитаар өгсөн 7 зөвлөмжөөс 3 зөвлөмж хэрэгжээгүй байна.

Зөвлөмжийн биелэлт 57.1 хувьтай байна. Өмнөх аудитаар өгсөн дараах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Хүснэгтээр харуулав.

Хүснэгт 4:

Зөвлөмж өгөгдсөн байгууллага албан тушаалтан	Зөвлөмжийн агуулга
Шат, шатны ИТХ-ын дарга нар	Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5 –д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгүүлж байгаа эсэх, хуулийн 6.9-д заасан мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэхэд хяналт тавих.
Бүх шатны Засаг дарга нар	Байгууллага, албан тушаалтнуудын ажлыг дүгнэхдээ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үзүүлэлт болгож байх.
Санхүү хяналт, аудитын албаны дарга В.Нэргүй	Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалтыг хэрэгжүүлэхдээ мэдээллийн агуулга, стандарт, үнэн зөв байдлыг үнэлэн үр дүнг тооцон ажиллах.

Нийцлийн аудитаар нийт 33,240.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

ДҮГНЭЛТ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг шат шатны ИТХ болон холбогдох байгууллагын нягтлан бодогч нар хэрэгжүүлээгүйгээс улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд мэдээллээ байршуулаагүй зөрчил байсаар байна.
2. Шилэн дансны мэдээллийг иргэн олон нийтэд хүргэх хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан албан тушаалтан ажлын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс зөрчлүүд давтагдаж байна.
3. Аймгийн ТЕЗ түүний харьяа байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэхдээ Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4¹⁹ -д заасны дагуу аудитад хамрагдсан байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт болгож, үр дүнг бодитой үнэлээгүйгээс зөрчил давтагдах шалтгаан болж байна.
4. Санхүүгийн хяналт, аудитын алба нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийхдээ мэдээллийн агуулга, стандарт, үнэн зөв эсэхийг үнэлээгүй байна.
5. Шилэн дансны тухай хууль, шилэн дансны мэдээллийн талаар иргэд олон нийтийн дунд сургалт сурталчилгаа хийгдээгүй, иргэдийн оролцоо байхгүй байна.

¹⁹ Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга-д:

1. Шилэн дансны тухай хууль, шилэн дансны мэдээллийн талаар иргэд олон нийтийн дунд сургалт сурталчилгааг идэвхжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах.
2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллах.

Аймгийн Засаг даргад:

1. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлэн, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ шилэн дансны хөтлөлтийг шалгуур үзүүлэлт болгосныг хэрэгжүүлж ажиллах.
2. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д заасан аж ахуй нэгж, байгууллагуудтай байгуулах гэрээнд шилэн дансанд мэдээлэх үүрэг, хариуцлагын талаар тусгаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.
3. Зөрчил гаргасан Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан холбогдох албан тушаалтанд²⁰ хариуцлагын арга хэмжээ авч ажиллах.

Санхүү, хяналт аудитын албаны дарга В.Нэргүйд:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалтыг хэрэгжүүлэхдээ мэдээллийн агуулга, стандарт, үнэн зөв байдлыг үнэлэн үр дүнг тооцон ажиллах.

²⁰ Хавсралт 1-ээс хавсралт 5-д заасан байгууллагуудын зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан

ҮАГ-т хүргүүлэх санал:

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйл:

1. 8.1.Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ гэсэн заалт хэрэгжээгүй тохиолдолд хэрхэн шийдвэрлэж байх талаар шилэн дансны тухай хуулийн хяналт хариуцлага хэсэгт тусгаж өгөх.
2. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д заасан аж ахуйн нэгж, байгууллагуудыг холбогдох мэдээллээ байршуулаагүй тохиолдолд хэрхэн шийдвэрлэж байх талаар шилэн дансны тухай хуулийн хяналт хариуцлага хэсэгт тусгаж өгөх.

Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

/Сая төгрөгөөр/

№	Илэрсэн зөрчлийн	Албан шаардлага		Төлбөрийн акт		Өгсөн зөвлөмж			
		Утга	Тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	
А	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт:								
1	Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-д заасан байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6.1 дэх заалттай холбоотой мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн зөв, иж бүрэн мэдээлээгүй байна.	290	-					290	
2	Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-д заасан байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6.4 дэх заалттай холбоотой мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн зөв, иж бүрэн мэдээлээгүй байна.	267	6,110.7	267	6,110.7				
3	Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-д заасан байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6.8 дэх заалттай холбоотой мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн зөв, иж бүрэн мэдээлээгүй байна.	60	663.6					60	663.6
4	Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-д заасан байгууллагууд Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 5.1 дэх мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн зөв, иж бүрэн мэдээлээгүй байна.	141	26,242.3					141	26,242.3
5	Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-д заасан байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6.9 дэх заалттай холбоотой мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн зөв, иж бүрэн мэдээлээгүй байна.	4	224.0					4	224.0
НИЙТ ДҮН		762	33,240.6	267	6,110.7			495	27,080.0

Шилэн дансны тухай хуулийн 6.1.1-6.1.6 д заасан мэдээллийг дараах байгууллагууд мэдээлээгүй байна.

№	Байгууллагын нэр	Шилэн дансны тухай хуулийн 6.1 дэх заалтын мэдээлэл									
		6.1.1 Тухайн жилийн төсөв	6.1.1. ХАА-ны төлөвлөгөө	6.1.2 Төсвийн гүйцэтгэлийн мэдээ	6.1.3. Дараа жилийн төсвийн төсөл	6.1.4. Санхүүгийн тайлан /хагас жил/	6.1.4. Санхүүгийн тайлан /Жилийн эцсээр/	6.1.5. ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт	6.1.5. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	6.1.6. Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	Нийт мэдээлээгүй гүйлгээний тоо
1	Арбулаг сумын ерөнхий боловсролын сургууль	-		2	1				1		4
2	Арбулаг сумын төсвийн ерөнхийлөн захирагч	-		2	1				1		4
3	Улаан-Уул сумын төсвийн ерөнхийлөн захирагч			-	1	1			1		3
4	Улаан -Уул сумын ерөнхий боловсролын дунд сургууль	1	1	2	1		1	1	1		8
5	Улаан -Уул сумын хүүхдийн цэцэрлэг	1	1	2	1	1	1	1	1		9
6	Улаан -Уул сумын соёлын төв	1	1	2	1	1	1	1	1		9
7	Улаан -Уул сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал	-	1	1	1	1	1	1	1		7
8	Улаан -Уул сумын засаг даргын тамгын газар	-	1	-	1		1	1	1		5
9	Ханх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1		-	1		1				3
10	Ханх сумын засаг даргын тамгын газар	1		-	1		1				3
11	Ханх сумын соёлын төв	-		-	1	1	1				3
12	Хатгал тосгоны засаг даргын тамгын газар	1	1	1	1	1			1		6
13	Цагаан-Үүр сумын 10-н жилийн сургууль	-	1	-	1			1			3
14	Цагаан-Үүр сумын соёлын төв	-		2	1			1	1		5
15	Цэцэрлэг сумын төсвийн ерөнхийлөн захирагч						1	1	1		3
16	Ирээдүй хорин нэгдүгээр зуун цогцолбор сургууль	1		-	1					1	3
17	Хүүхдийн уран дөш зуслан орон нутгийн өмчит ААТҮГ	1		7			1				9

18	Мөнххаан савдаг орон нутгийн өмчит ААТҮГ	1	1	8	1	1	1	1	1	1	16
19	Эрчимт идэр сум дундын ойн анги орон нутгийн өмчит ААТҮГ	1		-		1	1		1		4
20	Баян шишгэд сум дундын ойн анги орон нутгийн өмчит ААТҮГ	1	1	14	1	1			1		19
21	Хатгалцахир орон нутгийн өмчит ААТҮГ	1		1		1	1				4
22	Дэлгэрмөрөн сум дундын ойн анги Орон нутгийн өмчит ААТҮГ	1		12	1	1			1		16
23	Хөвсгөл-Энэрэл БГБХ-нөхөрлөл	-	1	3					1		5
24	Далайн-Элбэрэлт БГБХ-нөхөрлөл	-		3	1				1		5
25	Хөвсгөл дэлгэр мөрөн БГБХ-нөхөрлөл	-		14	1	1			1		17
26	Эрдэнэбулган сумын төсвийн ерөнхийлөн захиргач				1	1	1	1	1		5
27	Хөвсгөл аймгийн 7 дугаар цэцэрлэг	-		3	1	1	1	1		1	8
28	Иргэний нисэхийн харьяа Хөвсгөл нисэх буудал		1		1				1	1	4
29	Хөвсгөл аймгийн 4 дүгээр цэцэрлэг						1	1	1		3
30	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8 дугаар цэцэрлэг		1				1	1			3
Нийт дүн		13	12	79	23	14	17	13	21	4	196

Хавсралтад 3- аас дээш тооны мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байгууллагуудыг жагсааж харуулав.

Шилэн дансны тухай хуулийн 6.4.1-6.4.8-д заасан мэдээллийг дараах байгууллагууд мэдээлээгүй байна. Хавсралт-2

№	Байгууллагын нэр	6.4.1	6.4.2	6.4.3	6.4.4		6.4.5		6.4.5	6.4.6	6.4.7	6.4.8		Нийт мэдээлээгүй тоон дүн	Нийт мэдээлээгүй мөнгөн дүн	
		Мэдээлээгүй тоо	Мэдээлээгүй тоо	Мэдээлээгүй тоо	Мэдээлээгүй тоо	Мэдээлээгүй мөнгөн дүн /сая төг/	Мэдээлээгүй тоо	Мэдээлээгүй мөнгөн дүн /сая төг/	Мэдээлээгүй тоо	Мэдээлээгүй тоо	Мэдээлээгүй тоо	Мэдээлээгүй мөнгөн дүн /сая төг/				
1	Стандарт хэмжил зүйн хэлтэс							6	83.9			4	0.6	10	84.5	
2	Статистикийн хэлтэс						1	6.2	5	60.1				6	66.3	
3	Ус цаг уур орчны шинжилгээний төв				4	46.8			1	96.2				5	143.0	
4	Нийгмийн даатгалын хэлтэс	1			1	1.0			1	50.2		1	22.9	4	74.1	
5	Цагаан-уул сумын сумын хүн эмнэлэг								12	383.3				12	383.3	
6	Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сум хүн эмнэлэг								3	102.3				3	102.3	
7	Байгаль орчин, аялал жуулчлалын газар								9	921.2				9	921.2	
8	Бүрэнтогтох сумын бүрэнхаан цэцэрлэг				1	7.3	1	7.3	1	49.7				3	64.3	
9	Бүрэнтогтох сумын хүн эмнэлэг						5	58	1	232.2				6	290.2	
10	Галт сумын хүн эмнэлэг								1	10.2	1		1	2.0	3	12.2
11	Галт сумын төсвийн ерөнхийлөн захирагч		1	1	6	19					1			10	1,516.7	
12	Жаргалант сумын хүн эмнэлэг			1					4	130.9				5	130.9	
13	Жаргалант сумын хүүхдийн цэцэрлэг			1					3	128.6				4	128.6	
14	Жаргалант сумын засаг даргын тамгын газар								6	227.2				6	227.2	
15	Жаргалант сумын төсвийн ерөнхийлөн захирагч			1										2	973.1	
16	Рашаант сумын 10-н жилийн сургууль						4	93.5	1	13.9				5	107.4	

17	Рашаант сумын Хүүхдийн цэцэрлэг							3	49.7			5	18.2	8	67.9	
18	Тариалан сумын ерөнхий боловсролын дунд сургууль											5	25.3	5	25.3	
19	Тариалан сумын соёлын төв											4	82.3	4	82.3	
20	Тосонцэнгэл сумын хүн эмнэлэг			1	4	46.6			7	174.5				12	221.1	
21	Тосонцэнгэл сумын засаг даргын тамгын газар			1					7	147.1			4	5.0	12	152.1
22	Улаан -Уул сумын ерөнхий боловсролын дунд сургууль											21	147.9	21	147.9	
23	Цагаан-уул сумын Соёлын төв						1	6	2	18.0				3	24.0	
24	Цагаан-уул сумын Засаг даргын тамгын газар								4	32.8				4	32.8	
25	Цагаан-Үүр сумын 8-н жилийн сургууль								10	580.1				10	580.1	
26	Цагаан-Үүр сумын хүүхдийн цэцэрлэг								10	240.4				10	240.4	
27	Цэцэрлэг сумын хүүхдийн цэцэрлэг								4	90.0				4	90.0	
28	Хөвсгөл дэлгэр мөрөн БГБХ-нөхөрлөл		1	1							1			3	-	
29	Хөвсгөл гурван гал БГБХ-нөхөрлөл								9	58.5				9	58.5	
30	Хөвсгөл энх үйлс БГБХ-нөхөрлөл								8	53.4				8	53.4	
Мэдээлээгүй дүн		1	2	7	16	120.8	12	171	118	3,934.4	3	0	38	304.2	197	4,530.4

Хавсралтад 3-аас дээш тооны мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байгууллагуудыг жагсааж харуулав.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-д заасан мэдээллийг дараах байгууллагууд мэдээлээгүй байна.

Хавсралт-3

№	Байгууллагын нэр	3.2.8. Засгийн газар, орон нутгийн баталгаа, Төрийн байгууллага, улсын төсөвтэй холбоотой үүссэн өрийн талаарх шийдвэр, мэдээлэл		3.2.8 Засгийн газар, орон нутгийн баталгаа, Төрийн байгууллага, улсын төсөвтэй холбоотой үүссэн авлагын талаарх шийдвэр, мэдээлэл		6.8.2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө хугацаандаа мэдээлээгүй тоо	6.8.2. Худалдан авах ажиллагааны тайлан хугацаандаа мэдээлээгүй тоо	6.8.2. Тендер, худалдан авалтын ерөнхий мэдээлэл мэдээлээгүй тендрийн тоо	6.8.2. Тендер, худалдан авалтын ерөнхий мэдээлэл мэдээлээгүй тендрийн мөнгөн дүн /сая төг/	6.10 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.9 дүгээр зүйлд заасан мэдээлэл мэдээлээгүй тоо
		Мэдээлээгүй тоо	Мэдээлээгүй мөнгөн дүн (сая.төг)	Мэдээлээгүй тоо	Мэдээлээгүй мөнгөн дүн (сая.төг)					
1	Хөвсгөл дулааны станц ТӨХК						1			
2	Хөвсгөл эрчим хүч ХХК					1	1			
3	Хөвсгөлийн эргэлтийн эмийн сан					1	1			
4	Хоймор нутгийн чулуу ХХК	1	40.0			1	1			
5	Хөвсгөл ус суваг						1			2
6	Шинэ-Мөрөн худалдааны төв ХК					1	1			
7	Хөвсгөл АЗЗА ТӨХК						1			
8	Шинэ-Идэр дулаан эрдэнэт ХХК					1	1			
9	Галт дулаан ХХК						1			
10	Түнэл Илч ХХК						1			
11	Тэсийн илч ХХК						1			
12	Тариалан НАҮТ ХХК			1	79.9	1	1	13	277.2	1
13	Тосон Илч ХХК						1	10	109.5	1
14	Их-Уул дулаан ХХК					1	1	8	157.0	1
15	Могойн гол ХК						1			
ТЕЗ-ийн НИИТ ДҮН		1	40.00	1	79.9	7	15	31	543.7	5

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ
ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ
БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

Хавсралт-4

Хамрах хугацаа : 2017 оны 4-р улирал-2018 оны 3-р улирлыг дуустал

Хуулийн үйлчлэх хүрээ	Байгууллагын нэр	Мэдээлээгүй гүйлгээний тоо				
		Санхүүжилт өссөн дүнгээр / сая.төг /	4-р улирал /2017 он/	1-р улирал	2-р улирал	3-р улирал
1	Ану булаг ХХК	50.0			1	1
2	Бадрангуй-Орших ХХК ХӨ-2018/3.4.2-Б/2	70.3			1	1
3	Батжин Ундрах ХХК	279.3			1	1
4	Бодь-Электроникс ХХК ХӨ-2018/3.4.1-Б/1	28.8			1	1
5	Бунбах ХХК	132.7			1	1
6	Денсфорист ХХК	15.0			1	1
7	Дулаан хан трейд ХХК	19.8			1	1
8	Кибер жаал ХХК	23.9			1	1
9	Кореа серажем ХХК	70.0			1	1
10	Лүндээ-Очир ХХК	24.2			1	1
11	Монголын загас хамгаалах тул холбоо Нийгэмд үйлчлэх ТББ	25.0			1	1
12	Сант өндөр ХХК, ХӨ-2018/3.2.3-А/01	14.6			1	1
13	Сондоргоо ХХК	184.3			1	1
14	Туурайн тамга ХХК	92.9			1	1
15	Тэнгэр хишиг ХХК	300.6			1	1
16	Хөвсгөл булаг ХХК	927.0			2	2
17	Хөвсгөл галт ХХК	33.5			1	1
18	Хөвсгөл Зам ХХК	993.1			3	5
19	Хөвсгөл мон трейвэл	19.5			1	1
20	Хөвсгөл хүрмэн ХХК	68.7			2	2
21	Цэцүүх трейд ХХК	-			1	1
22	Чамбай зам ХХК	214.4			1	1
23	Эв УХАТ ХХК	40.3			2	2
24	Тосон бүргэдэй ХХК	24.2			1	1
25	Интерпресс ХХК	52.8			2	2
26	Шинэ Эрдэнэт Констракшн ХХК	225.1			1	1
27	Ай Си Ти Сайн консалтинг ХХК	27.4			1	1
28	Батжин-Ундрах ХХК	215.9			1	1
29	Бодь-Электроникс ХХК	28.8			1	1
30	Бөртэ- Өргөө ХХК	32.4			1	1
31	Буянт тээлийн хишигхоршоо	9.1			1	1
32	Буянт Хишигт Ундрага ХХК	21.0			1	1
33	Вест ченж ХХК	26.7			1	1

34	Гурван Гал Мед ХХК	-			1	1
35	Даян дээрх эко ХХК	44.9			1	1
36	Денсфорист ХХК	15.0			1	1
37	Дэрэн наран ХХК	154.8			1	1
38	Агар Эрдэнэс трейд ХХК	183.3			1	1
39	Жанст ундрал ХХК	28.3			1	1
40	Жанхай оргил ххк	27.2			1	1
41	Жинчингранд ХХК	30.0			1	1
42	Жишиг Проект ХХК	15.0			1	1
43	Их монгол тревел ххк	19.6			1	1
44	Их сант хайрхан ХХК	27.1			1	1
45	Их харгана ундрга ХХК	35.0			1	1
46	Монгол жайнт трейд ХХК	13.6			1	1
47	Моносфарм трейд ХХК	69.1			1	1
48	Морин сувд ХХК	800.0			1	1
49	Мөнх Өсөн нэмэх ХХК	44.9			1	1
50	Мөнх Алтан мандал ХХК	26.3	1			
51	Мянган хоньт ХХК	22.4			2	2
52	Намуун Мөрөн ХХК	23.3			1	1
53	Наранмандал хайрхан ХХК	18.9			1	1
54	Ойн цэцэрлэг ХХК,	33.5			1	1
55	Оргилуун мөрөн ХХК	18.9			1	1
56	Оркон тех ХХК,	547.4			2	2
57	Отгонширэвгэр ХХК	28.3			1	2
58	Өгөөмөр Ундрах хоршоо	35.0			1	3
59	Өрөлт ХХК	26.4			1	1
60	Погада ХХК	14.3			1	1
61	Сант-Өндөр ХХК	261.0			1	1
62	Тод горхи ХХК	36.7		1	2	2
63	Тэмээн ХХК	159.8	1	1		1
64	Улаан булаг морьт ххк	46.0		1	1	1
65	Урагшлах	579.5			2	2
66	Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэр ТӨААТҮГ	59.1			1	1
67	Шидэтгал ххк	43.6			2	2
68	Хас жолоо ХХК	34.8	1		1	1
69	Хоймор нутгийн чулуу ХХК	84.0			1	1
70	Хөвсгөл АЗЗА ТӨХК	421.5		1	2	2
71	Хөвсгөл бат чандмань ХХК	303.0			1	1
72	Хөвсгөл булаг хХК	3,760.5	1	1	2	1
73	Хөвсгөл Геологи ХК	737.7	1	1	1	1
74	Хөвсгөл далай ээж нийгэмлэг ТББ	10.0			1	1
75	Хөвсгөл жугнай ХХК	40.0			1	1
76	Хөвсгөл мичид ХХК	230.0			1	1
77	Хөвсгөл Монтрэйвел ХХК	19.1		1	1	1
78	Хөвсгөл Эрмүүн-Оч ХХК	9,411.4		1	2	2

79	Хөвсгөл Эх ХХК	503.9	1	1	1	2
80	Чамбай зам ХХК	212.0		1	1	1
81	Хөвсгөл геологи ХК	911.8			2	2
82	ХБС ХХК	340.0			1	1
83	Нөхөрлөл зам хоршоо	60.0			1	1
84	Овоо нам ХХК	4.5			1	1
85	Сүлдбумбат ХХК	57.5			2	2
86	Монгол жайнт трейд ХХК	34.9			1	
87	Брайт Гламоур ХХК	17.2			1	1
88	Бунбах ХХК	45.6			1	1
89	Идэрчандмань ХХК	841.3			1	1
90	Хөвсгөл өргөө ХХК	26.9			1	1
91	Хөх тэнгэр Хөвсгөл ХХК	104.5			1	1
92	Анар принт ХХК	250.8			6	6
	3.1.4-ийн НИЙТ ДҮН	26,242.3	6	10	111	116

Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-д заасан мэдээллийг дараах байгууллагууд мэдээлээгүй байна.

Хавсралт-5

		Санхүүжилт өгсөн байгууллагын нэр	Хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжүүлэх хугацаа /он сар өдөр/		Хэрэгжилтийн явц, үе шат /өссөн хувиар/	Нийт төсөвт өртөг / сая.төг /	Санхүүжилт өссөн дүнгээр / сая.төг /	Тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд гаргасан зардал өссөн дүнгээр / сая.төг /	2017 оны 4 дүгээр улирал мэдээлээгүй тоо	1-р улирал мэдээлээгүй тоо	2-р улирал мэдээлээгүй тоо	3-р улирал мэдээлээгүй тоо
				эхлэх	дуусах								
1	Тэмүүлэл хүүхдийн цэцэрлэг	Мөрөн сумын ТЕЗ	Хүүхдийн цэцэрлэг	2017.09.01	2019.06.01	70.0	91.0	63.8	63.8	1	1	1	1
2	Гранд хүүхдийн цэцэрлэг	Мөрөн сумын ТЕЗ	Хүүхдийн цэцэрлэг	2017.09.01	2019.06.01	69.9	71.3	49.9	49.9			1	1
3	Далай ван сургууль	Мөрөн сумын ТЕЗ	Сургууль	2017.09.01	2019.06.01	79.2	107.8	85.4	85.4	1	1	1	1
4	Индиго цэцэрлэг	Мөрөн сумын ТЕЗ	Хүүхдийн цэцэрлэг	2017.09.01	2019.06.01	69.9	35.6	24.9	24.9	1	1	1	1
Нийт дүн						72.3	305.7	224.0	224.0	3	3	4	4



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2018 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/58

Мөрөн сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2018 оны А/125 дугаар тушаал, 2018 оны А/207 дугаар тушаалын тавдугаар хавсралтын 1.3 дахь заалт, 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан “Нийцлийн аудитын түр журам”-ын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Санхүүгийн хяналт, аудитын алба, сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Л.Төмөрбаатар), аймгийн Засаг дарга (Л.Ганболд), Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга (В.Нэргүй), сумдын Засаг дарга нарт зөвлөсүгэй.
5. Нийцлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер (Ж.Отгончимэг), нийцлийн аудитын албаны ахлах аудитор (Л.Энх-Амгалан) нарт даалгасугай.
6. Аудитын тайланг батлагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг нийцлийн аудитын албаны ахлах аудитор (Л.Энх-Амгалан), энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер (Ж.Отгончимэг) нарт үүрэг болгосугай.


ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ГАНБОЛД

1551158

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 1/58 тоот тушаалын хавсралт



Акт, албан шаардлагын жагсаалт

/сая.төгрөгөөр/

№	Дугаар	Зөрчлийн утга	Мөнгөн дүн
Б	Албан шаардлага		
1	ХӨА-2018/01/- НА-01/31	Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, аудитаар материаллаг хэмжээний алдаа зөрчил илэрсэн. Хариуцлага тооцох албан шаардлага	6,110.7
Дүн			6,110.7

___ооОоо___



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Л.ГАНБОЛД
ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93
Э-мэйл: khuvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2018.11.27 № 262-2018/01-НА-ХөТАГ-01/49

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол улсын Ерөнхий аудиторын 2015 оны А/125 дугаар тушаал, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Өмнөх онд гүйцэтгэсэн нийцлийн аудитаар өгсөн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалтыг хэрэгжүүлэхдээ мэдээллийн агуулга, стандарт, үнэн зөв байдлыг үнэлэн үр дүнг тооцон ажиллах” гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.
2. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан чиг үүргийн дагуу Санхүүгийн хяналт, аудитын алба нь хяналтыг хэрэгжүүлэхдээ шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдсан мэдээллийн агуулга, нийтлэг стандарт, үнэн зөв байдалд анхаарал хандуулахгүй байгаагаас зөрчил давтагдаж байна. Нийцлийн аудитаар 8,628,600,000 / Найман тэрбум зургаан зуун хорин найман сая зургаан зуун мянга / төгрөгийн зөрчил илэрлээ.


Иймд: Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д (Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, аудитад нөлөөлөхийг оролдсон, санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга В.Нэргүйд сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Аймгийн Засаг дарга Л.Ганболдод даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Л.Энх-Амгалан
 Аудитор Э.Бат-Эрдэнэ
 Аудитор С.Гансүх
 Хянасан:
 Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер Ж.Отгончимэг



ЗӨВШӨӨРСӨН:

Аймгийн Засаг дарга Л.Ганболд



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

1751422